

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2009 он)

1.Техник хангалтын албаны Удирдлага Хяналтын Төвийн тэжээлийн системд гарсан саатал Зөвлөмж:01-02

ЗӨВЛӨМЖ: 20090201

VSAT,GAREX,MARC, сансрын холбоо зэрэг сэргээгдэхдээ хугацаа шаарддаг системүүдийн нам талын тэжээлийн эх үүсвэрийг нөөцтэй болгох

ЗӨВЛӨМЖ: 20090202

Удирдлага Хяналтын Төвд байрладаг Нислэгийн хөдөлгөөний удирдлагын Шанд, Мөрөн секторын хэвийн ажиллагаа алдагдах үед ажиллах нөөц системтэй болох

2."Аэромонголиа" ХХК-ийн JU-8251 дугаартай F-50 агаарын хөлгийн хөдөлгүүрийг агаарт унтрааж буулт хийсэн. Зөвлөмж:03-07

ЗӨВЛӨМЖ:20090303

Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх дүрэм 145-ийн холбогдох заалтууд техник үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэл, чанарын хяналт баталгаажуулалтын зохион байгуулалт, тэдгээрт тавигдах шаардлагыг боловсронгуй болгох.

ЗӨВЛӨМЖ:20090304

Иргэний нисэхийн дүрэм 145-ийн заалтуудыг бүрэн хэрэгжүүлсний дагуу Аэромонголиа болон бусад компанийн техник үйлчилгээний нэгжүүдийг гэрчилгээжүүлэх

ЗӨВЛӨМЖ:20090305

Хөдөлгүүр болон түүний модулиудын Overhaul хэлбэрийн техник үйлчилгээнд орох хугацааг тодорхой болгох

ЗӨВЛӨМЖ:20090306

Монгол улсад бүртгэлтэй агаарын хөлгийн хөдөлгүүр болон эд ангиудыг "On-condition maintenance program"-ын дагуу ашиглахад ИНЕГ-аас баримтлах бодлого, тавигдах шаардлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх

ЗӨВЛӨМЖ:20090307

Агаарын тээвэрлэгч компаниудын техникийн бичиг баримтанд тавих хяналтыг сайжруулж нислэгт тэнцэх чадварын байцаагч нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, инженерингийн сургалтанд бүрэн хамруулах

3. ИНЕГ-ын НХҮА, ТХА, НМХА, Аэронавигацийн Мэргэжлийн хэлтэст хийсэн шинжлэн шалгасан ажлын тайлан. Зөвлөмж: 08-21

ЗӨВЛӨМЖ:20090608

НХҮА, ТХА, Аэронавигацийн мэргэжлийн хэлтэс байгууллагын дүрэм, үйл ажиллагааны заавар, технологийг шинээр боловсруулах, мөрдөж байгаа үйл ажиллагааны заавар боловсронгуй болгох зарим өөрчлөлт (стандарт, технологийг салгах г.м) оруулан батлан мөрдөх

ЗӨВЛӨМЖ:20090609

НХҮА-ны Шуурхай мэдээллийн хэсгийн үйл ажиллагааг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 29.1 дүгээр заалт болон аппех 12, бусад холбогдох баримт заалтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн оноосон нэр, дүрэм, үйл ажиллагааны заавар, технологийг шинээр боловсруулан батлаж мөрдөх, ОХУ-тай байгуулсан гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажил болгох

ЗӨВЛӨМЖ:20090610

Монгол улсын нутаг дэвсгэр дээр нисэхийн салбарт гарсан нислэгийн ослыг эрэн хайх авран туслах үйл ажиллагааны ерөнхий зарчмыг холбогдох (ОБЕГ, БХЯ г.м) байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулан баталгаажуулах замаар тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө гаргаж мөрдөх

ЗӨВЛӨМЖ:20090611

КОСПАС-SARSAT-аас ослын тухай мэдээлэл хүлээн авах үйл ажиллагааг олон улсын буюу гадаадын холбогдох байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах замаар эрх үндсийг бүрдүүлж, албан ёсны болгон баталгаажуулах

ЗӨВЛӨМЖ:20090612

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын үзүүлэх радарын, процедурын мэдээллийн үйлчилгээний стандарт болон нислэгийн удирдагч нарыг шинээр бэлтгэх, үйлдвэрлэлийн нөхцөлд сургах, ажлын байрны сургалтын стандартыг ICAO-гийн аппех 11, док 4444, 9426, 9432 баримт бичигт тулгуурлан бий болгон мөрдөж ажиллах

ЗӨВЛӨМЖ:20090613

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа “Радарын үйлчилгээ үзүүлэх” бодит боломж нь ICAO-гийн 9426 баримт бичигт заасан Радарын үйлчилгээ үзүүлэх тухай шаардлагыг хэрхэн хангаж байгааг тодорхойлж, үл тохирлыг тогтоон процедурын буюу мэдээллийн үйлчилгээний аргад шилжих үеийн технологи үйл ажиллагааны зааврыг тогтоон ажиллах

ЗӨВЛӨМЖ:20090614

Улаанбаатарын Чингис хаан нисэх буудлын нислэг үйлдэх зааварт тусгагдаагүй байгаа 148, 142 градусын чиглэлд хөөрөх, 148, 322 градусын чиглэлээр буух заавар гаргаж холбогдох бүрэлдэхүүнд судлуулж, мөрдөх

ЗӨВЛӨМЖ:20090615

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2001 оны 55, 268 тоот тушаалаар тогтоосон аэродромын орчмын аюулгүй байдлын стандартын биелэлтийг гаргаж нислэгийн аюулгүй байдлын шаардлагыг хангах арга хэмжээ авах

ЗӨВЛӨМЖ:20090616

Нислэгийн удирдагчын үйл ажиллагааны заавар технологийг боловсронгуй болгох, тэдний онгоц, нисдэг тэрэг, аэродинамикийн болон нислэгийн талын мэдлэгийг дээшлүүлэх талаар сургалт дадлагын ажлыг зохион байгуулах

ЗӨВЛӨМЖ:20090617

В-330 (Алтай хот), В-480 (Арвайхээр хот), М-520 (Өндөрхаан хот), G-218 (Чойбалсан, Баруун-Урт хот) агаарын замуудтай ойролцоо орших аймаг хот төв, суурин газар дайрч өнгөрөх боломжийг судлаж, шийдвэрлэх

ЗӨВЛӨМЖ:20090618

Агаарын замууд огтолцож байгаа цэгүүдэд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэхэд анхаарах асуудлыг нислэгийн төлөвлөлтийн шатнаас нислэгийн үйлчилгээ үзүүлэх хүртэлх бүх үе шатуудад урьдчилан дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

ЗӨВЛӨМЖ:20090619

Агаарын зам тус бүрийг RNP-гийн аль ангилалд хамаарахыг тогтоож, зарим агаарын замд судалгаа хийж үзэх тухайлбал POLHO-UDA-гийн В339. Энэ замаар явагдах нислэгийг М520, Хэнтий-Улаанбаатарын агаарын зам ашиглах боломж байгаа эсэхийг судлаж шийдвэрлэх.

ЗӨВЛӨМЖ:20090620

ИНЕГ-ын Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Техник хангалтын албад нь захиргаа, дотоод ажил, боловсон хүчний талаарх асуудлыг ИНЕГ-ын дотоод журамд нийцүүлэн байгууллагынхаа үйл ажиллагааны зааврын холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл байгууллагын дүрэм гаргах замаар шийдвэрлэх

ЗӨВЛӨМЖ:20090621

Аэронавигацын үйлчилгээний тоног төхөөрөмжийн бэлэн байдлын үзүүлэлтийг тоног төхөөрөмж тус бүрээр гаргаж, найдварт ажиллагааны төвшинг ТХА болон иргэний нисэхийн системийн хэмжээнд тогтоож холбогдох арга хэмжээ авч байх

4. Изнис ХХК-ний SAAB-340 маягийн агаарын хөлөг Увс аймгийн Улаангом хотын аэродромд шувуутай мөргөлдсөн шалтгааныг шинжлэн шалгасан ажлын тайлан. Зөвлөмж: 22-24

Зөвлөмж:20090922

Нисэх буудлын орчинд шувуу их хэмжээгээр цугларсан нөхцөл байдлыг мэргэжлийн үүднээс орнитологийн судалгаа шинжилгээг хийлгэж холбогдох арга хэмжээг авах.

Зөвлөмж:20090923

Шувуу их хэмжээгээр цугларсан байдлыг арилгах, нисэх буудлын нислэгийн аюулгүй ажиллагааг хангах нөхцөл бүрдтэл Увс аймгийн нисэх буудалд нислэг үйлдүүлэхгүй байх.

Зөвлөмж 20090924

Шувууны эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтын систем бий болгож, эрх зүйн орчныг тогтоож мөрдүүлэх

5. Изнис эйрвейз JU 9901 дугаартай СААБ 340 маягийн агаарын хөлөг Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудалд шороон зурвасаар явгалах үед зүүн талын дугуй шигдэж зогссон. Зөвлөмж:25-36

ЗӨВЛӨМЖ:20091025

Монгол улсад ашиглагдаж байгаа хөөрөх буух зурвастай аэродромуудын зураг, төсөл, даацын тоо, байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан бичиг баримтуудыг бүрдүүлэх, баталгаажуулах.

ЗӨВЛӨМЖ:20091026

Хатуу хучилттай болон шороон зурвастай аэродромуудыг байгуулах стандартыг тогтоож өгөх.

ЗӨВЛӨМЖ:20091027

Монгол улсад ашиглагдаж байгаа хөөрөх буух зурвасууд, зогсоолууд, явгалах замуудын даацын тооцоог шалгах, одоо АИП-д байгаа даацын мэдээлэлтэй харьцуулан шинэчлэх,

ЗӨВЛӨМЖ:20091028

Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа хөөрөх буух зурвасууд, явгалах зам, зогсоолуудын даац, хязгаарлалтыг техникийн аргаар тодорхойлдог болох.

ЗӨВЛӨМЖ:20091029

Нисэх буудлуудын “Аэродромын үйл ажиллагааны заавар”-ыг боловсронгуй болгож, заалт бүрт тодорхой зааварчилгаа, ажиллагааны горим, дараалал, үзлэг шалгалтын хөтөлбөр, хугацаа, нөхцөл байдал, арга зам, тавигдах шаардлагууд, өгөгдэхүүн, хязгаар, холбогдох байгууллагуудтай хамтрах, харилцан ажиллах журам, дараалал зэргийг нэг бүрчлэн, нарийвчлан ойлгомжтой тусгасан байх.

ЗӨВЛӨМЖ:20091030

Аэродромын үзлэг шалгалт хийх гарын авлагад шороон зурвасуудыг ангилан, тэдгээрт тавигдах шаардлагууд, хийгдэх үзлэг , шалгалтуудыг нарийвчлан тусгах.

ЗӨВЛӨМЖ:20091031

Аэродром хариуцсан мэргэжлийн ажилтнуудыг давтан сургалтанд тогтмол хамруулж, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх

ЗӨВЛӨМЖ:20091032

Шороон зурвасуудын даацыг тогтоох аргачлал, гарын авлагыг боловсруулж, шаардлагатай багаж тоног төхөөрөмж, боловсон хүчнээр хангах

ЗӨВЛӨМЖ:20091033

Одоо ашиглаж байгаа шороон зурвасуудын CBR-ыг тогтоож, мэдээлж байх

ЗӨВЛӨМЖ:20091034

Өдөр тутмын аэродромуудын байдлын мэдээлэлд хөөрөх буух зурвасны нөхцөл байдалтай холбогдолтой мэдээг дэлгэрэнгүй оруулж байх

ЗӨВЛӨМЖ:20091035

Аэродромын ашиглалт, засвар үйлчилгээ, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох

ЗӨВЛӨМЖ:20091036

Аэродром байгуулах ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гүйцэтгэлийн баримт материалыг хадгалах, архивлах тогтолцоог бордүүлэх